



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/207

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус аймгийн Баянжаргалан сумд үйл ажиллагаа явуулдаг "Үнэн анд" ХХК-ний жоншны уурхайд ажиллах хүч нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ-аас нэвтрүүлж буй иргэдийн тусгаарлах байранд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Дугар (Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, Ахлах дэслэгч)

Гишүүд: Ц.Энхсайхан (Онцгой байдлын газрын Эмч-Сэтгэл зүйч, Ахлах дэслэгч)  
Н.Батбаяр (Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 25 дугаар ангийн Аврагч, гал сөнөөгч, Ахлах ахлагч)  
Б.Далхсүрэн (Цагдаагийн газрын Баянжаргалан сумын хэсгийн цагдаа, Дэд ахлагч)

Хоёр. Тусгаарлан ажиглах байрны халдвар хамгааллын дэглэмийг холбогдох дүрэм, журмын дагуу хангуулж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээг тухай бүр нь аймгийн Онцгой комисст танилцуулахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010580